

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/141/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ХҮН ЭМНЭЛГИЙН
2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай Аудит” ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/105

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тогилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Б/68 дугаар "Эд хөрөнгийн тооллого явуулах тухай" тушаалаар тооллогын комиссыг 4 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тооллогыг гүйцэтгэхдээ биетээр гүйцэтгэж баталгаажуулаагүй, үр дүнг хэлэлцээгүй, Ковид-19 цар тахлын үед ажилласан албан хаагчдад олгох улаан бүсэд ажилласны нэмэгдэл хөлс 33,332.3 мянган төгрөгийг өмнөх онд ажилчидтай холбоотой өглөгөөр тусгаагүй, тайлант оны эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс олгосон, тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 42 нэр төрлийн 1,798.5 мянган төгрөгийн эм боох материал /эм, вакцин/ бүртгэлтэй зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж,

G/Arkhir/Alban bichig 2023/ A4

19020178

санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх", "Оршин байх", "Тасалбар болголт" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2022 оны 107 дугаар "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол, Засгийн газрын 2022 оны 194 дүгээр "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор албан хаагчдын цалинд өөрчлөлт орж нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант оноос эмнэлгийн үйлчилгээг цахимжуулан, E-Hospital программ хангамж ашиглах болсны улмаас их эмч, бага эмч нарт нэн шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж бэлтгэн төсвийн хөрөнгөөр худалдан авсан 16,221.4 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 80,919.3 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

G/Arkhir/Alban bichig 2023/ A4

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>145,865,247.06</u>	<u>141,570,171.57</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,603,261.18	52,043,393.53
312	Банканд байгаа бэлэн мөнгө	2,603,261.18	52,043,393.53
3121	Төгрөг	2,603,261.18	52,043,393.53
31211	Төрийн сангийн харилцах	2,603,261.18	52,043,393.53
33	АВЛАГА	74,039,200.00	741,215.75
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	741,215.75
335	Бусад авлага	74,039,200.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	74,039,200.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	69,222,785.88	88,785,562.29
351	Түүхий эд материал	27,798,112.75	30,294,671.16
35110	Тусгай зориулалттай материал	5,133,940.00	6,511,140.00
35130	Эм боох материал	22,664,172.75	23,783,531.16
354	Хангамжийн материал	41,424,673.13	58,490,891.13
35410	Бичиг хэргийн материал	564,300.00	564,300.00
35420	Аж ахуйн материал	40,569,110.63	57,146,401.13
35460	Хүнсний материал	291,262.50	780,190.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>525,347,258.53</u>	<u>566,746,398.45</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	525,347,258.53	566,746,398.45
392	Биет хөрөнгө	517,023,258.53	558,034,398.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	460,197,006.00	460,197,006.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-51,966,568.48	-74,764,373.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,480,000.00	106,810,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-54,780,000.00	-63,021,666.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	133,109,967.75	183,292,754.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,569,400.84	-77,294,074.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,947,502.64	34,527,330.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,344,915.43	-12,496,410.42
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,050,000.00	2,050,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,760,833.11	-1,926,666.59
39217	Ном	660,500.00	660,500.00
393	Биет бус хөрөнгө	8,324,000.00	8,712,000.01
39303	Бусад биет бус хөрөнгө	8,354,000.00	8,794,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-30,000.00	-81,999.99
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>671,212,505.59</u>	<u>708,316,570.02</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>25,887,742.00</u>	<u>1,901.54</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,887,742.00	1,901.54
413	Өглөг	25,887,742.00	1,901.54
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,901.54
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,546,172.00	00.00
4136	Бусад өглөг	18,341,570.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	18,341,570.00	00.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>645,324,763.59</u>	<u>708,314,668.48</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	645,324,763.59	708,314,668.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	220,397,712.25	220,397,712.25
51101	Өмч: - төрийн	220,397,712.25	220,397,712.25
512	Хуримтлагдсан үр дүн	259,328,059.82	322,317,964.71
51210	Өмнөх үеийн үр дүн	259,328,059.82	259,328,059.82
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	62,989,904.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	165,598,991.52	165,598,991.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>671,212,505.59</u>	<u>708,316,570.02</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	914,760,068.16	738,986,848.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	278,774,843.16	113,026,746.76
120	Нийтлэг татварын бус орлого	278,774,843.16	113,026,746.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,932,450.00	82,311,223.86
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	396,589,700.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	239,395,525.00	625,960,101.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	198,557,455.00	22,530,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,900,000.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	3,300,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,686,555.00	21,820,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,913,900.00	710,000.00
131106	Төсвийн урамшуулал	73,757,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,767,300.00	37,841,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,767,300.00	37,841,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,070,770.00	565,588,301.39
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,070,770.00	565,588,301.39
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	876,519,411.56	655,306,757.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	876,519,411.56	655,306,757.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	872,908,150.38	650,126,391.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,290,635.59	395,139,664.04
210101	Үндсэн цалин	205,667,815.01	212,878,548.86
210102	Нэмэгдэл	59,534,628.48	149,139,963.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,751,192.10	4,391,806.00
210104	Урамшуулал	33,337,000.00	28,729,345.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,234,481.23	48,545,311.00
210201	Тэтгэврийн даатгал	29,995,468.59	35,402,211.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,320,305.68	3,285,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,856,224.53	2,628,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	460,243.89	657,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,602,238.54	6,571,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,450,872.00	26,497,862.00
210301	Гэрэл, цахилгаан	4,735,472.00	3,782,462.00
210302	Түлш, халаалт	22,334,400.00	22,334,400.00
210303	Цэвэр, бохир ус	381,000.00	381,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,187,728.67	34,762,634.00
210401	Бичиг хэрэг	2,178,500.00	2,367,634.00
210402	Тээвэр, шатахуун	25,490,790.00	27,409,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,500,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,949,988.00	3,485,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	68,450.67	00.00
2105	Норматив зардал	254,406,168.74	51,081,877.11
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	243,195,965.24	39,545,004.61
210502	Хоол, хүнс	10,260,403.50	11,536,872.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	949,800.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,353,207.17	14,931,420.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,843,589.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,359,618.17	4,895,120.00
210604	Урсгал засвар	1,150,000.00	10,036,300.00
2107	Томилолт, зочны зардал	460,000.00	1,978,000.00
210702	Дотоод албан томилолт	460,000.00	1,978,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	193,525,056.98	77,189,623.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	134,903,838.26	20,056,149.29
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,621,218.72	57,133,473.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,611,261.18	5,180,366.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,603,261.18	5,180,366.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,603,261.18	5,180,366.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>38,240,656.60</u>	<u>83,680,090.77</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	20,690,185.88
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	20,690,185.88
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-20,690,185.88
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>38,240,656.60</u>	<u>62,989,904.89</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	562,228,225.00	699,717,101.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	562,228,225.00	699,717,101.39
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	396,589,700.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	124,800,455.00	96,287,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,900,000.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	3,300,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,686,555.00	95,577,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,913,900.00	710,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,767,300.00	37,841,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,767,300.00	37,841,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,070,770.00	565,588,301.39
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,070,770.00	565,588,301.39
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	562,228,225.00	634,055,579.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	562,228,225.00	634,055,579.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	558,616,963.82	628,875,213.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,291,435.59	395,139,664.04
210101	Үндсэн цалин	205,667,815.01	212,878,548.86
210102	Нэмэгдэл	59,534,628.48	149,139,963.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,751,192.10	4,391,806.00
210104	Урамшуулал	33,337,800.00	28,729,345.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,233,681.23	48,545,011.00
210201	Тэтгэврийн даатгал	29,994,668.59	35,402,211.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,320,305.68	3,285,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,856,224.53	2,628,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	460,243.89	657,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,602,238.54	6,571,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,617,300.00	27,331,434.00
210301	Гэрэл, цахилгаан	4,636,300.00	3,881,634.00
210302	Түлш, халаалт	21,600,000.00	23,068,800.00
210303	Цэвэр, бохир ус	381,000.00	381,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,235,000.00	34,909,434.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,499,534.00
210402	Тээвэр, шатахуун	17,235,000.00	27,409,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	3,500,000.00
2105	Норматив зардал	27,037,092.00	75,995,609.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,037,092.00	58,988,809.00

210502	Хоол, хүнс	9,000,000.00	17,006,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,481,500.00	25,143,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,200,000.00	4,813,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,131,500.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	1,150,000.00	15,330,000.00
2107	Томилолт, зочны зардал	460,000.00	1,978,000.00
210702	Дотоод албан томилолт	460,000.00	1,978,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,260,955.00	19,832,361.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	129,260,955.00	19,832,361.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,611,261.18	5,180,366.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,603,261.18	5,180,366.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,603,261.18	5,180,366.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	65,661,522.35
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	16,221,390.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	16,221,390.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	16,221,390.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	16,221,390.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-16,221,390.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	49,440,132.35
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	2,603,261.18
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	52,043,393.53

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	220,397,712.25	172,653,598.99	-96,292,534.35	296,758,776.89
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	220,397,712.25	172,653,598.99	-96,292,534.35	296,758,776.89
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
7	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,102,658.15	-11,102,658.15
8	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	220,397,712.25	165,598,991.52	259,328,059.82	645,324,763.59
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	220,397,712.25	165,598,991.52	259,328,059.82	645,324,763.59
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	220,397,712.25	165,598,991.52	259,328,059.82	645,324,763.59
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
16	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	62,989,904.89	62,989,904.89
17	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	220,397,712.25	165,598,991.52	322,317,964.71	708,314,668.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	645,982,800.00	644,136,603.04	1,846,196.96	99.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	645,982,800.00	644,136,603.04	1,846,196.96	99.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	645,982,800.00	644,136,603.04	1,846,196.96	99.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	383,992,100.00	395,139,664.04	(11,147,564.04)	102.90
210101	Үндсэн цалин	223,207,000.00	212,878,548.86	10,328,451.14	95.37
210102	Нэмэгдэл	121,146,700.00	149,139,963.59	(27,993,263.59)	123.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,300,000.00	4,391,806.00	1,908,194.00	69.71
210104	Урамшуулал	33,338,400.00	28,729,345.59	4,609,054.41	86.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,999,000.00	48,545,011.00	(546,011.00)	101.14
210201	Тэтгэврийн даатгал	34,818,000.00	35,402,211.00	(584,211.00)	101.68
210202	Тэтгэмжийн даатгал	3,295,400.00	3,285,800.00	9,600.00	99.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,636,100.00	2,628,500.00	7,600.00	99.71
210204	Ажилгүйдлийн даатгал	659,000.00	657,100.00	1,900.00	99.71
210205	Эрүүл мэндийн даатгал	6,590,500.00	6,571,400.00	19,100.00	99.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,217,300.00	27,331,434.00	885,866.00	96.86
210301	Гэрэл, цахилгаан	4,636,300.00	3,881,634.00	754,666.00	83.72
210302	Түлш, халаалт	23,200,000.00	23,068,800.00	131,200.00	99.43
210303	Цэвэр, бохир ус	381,000.00	381,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,909,900.00	34,659,434.00	250,466.00	99.28
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,499,534.00	466.00	99.98
210402	Тээвэр, шатахуун	27,409,900.00	27,159,900.00	250,000.00	99.09
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	3,500,000.00	-	100.00
2105	Норматив зардал	74,650,200.00	75,995,609.00	(1,345,409.00)	101.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,643,400.00	58,988,809.00	(1,345,409.00)	102.33
210502	Хоол, хүнс	17,006,800.00	17,006,800.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,550,000.00	35,256,190.00	3,293,810.00	91.46
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	14,926,190.00	73,810.00	99.51
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	18,550,000.00	15,330,000.00	3,220,000.00	82.64
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	1,268,000.00	732,000.00	63.40
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	1,268,000.00	732,000.00	63.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,664,300.00	25,941,261.00	9,723,039.00	72.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,664,300.00	25,941,261.00	9,723,039.00	72.74
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	645,982,800.00	698,757,101.39	(52,774,301.39)	108.17

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,841,800.00	37,841,800.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	37,841,800.00	37,841,800.00	-	100.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	511,854,000.00	660,915,301.39	(149,061,301.39)	129.12
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	511,854,000.00	660,915,301.39	(149,061,301.39)	129.12
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	96,287,000.00	-	96,287,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	96,287,000.00	-	96,287,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,603,261.18	(2,603,261.18)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		52,043,393.53	(52,043,393.53)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26.00	23.00	3.00	88.46
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	16.00	1.00	94.12
620003	Үйлчлэх ажилтан	8.00	6.00	2.00	75.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	960,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	960,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	960,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	250,000.00
2107	Томилолт, зочны зардал	710,000.00
210702	Дотоод албан томилолт	710,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	960,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	960,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	710,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлэг нь эрхэм зорилгоо “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сумын хүн амд чанартай, хүртээмжтэй хүргэх” гэж тодорхойлсон.

Тус байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сумын хүн амд чанартай, хүртээмжтэй хүргэн, эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49/А/118 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт “Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37,104.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,603.26	52,043.39	49,440.13
Авлага	74,039.20	741.22	(73,297.98)
Бараа материал	69,222.79	88,785.56	19,562.77
Үндсэн хөрөнгө	525,347.26	566,746.40	41,399.14
Нийт хөрөнгийн дүн	671,212.51	708,316.57	37,104.06
Өглөг	25,887.74	1.90	(25,885.84)
Засгийн газрын хувь оролцоо	220,397.71	220,397.71	-
Хуримтлагдсан үр дүн	259,328.06	322,317.96	62,989.90
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	165,599.00	165,599.00	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	671,212.51	708,316.57	37,104.06

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данснууд байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 49,440.1 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахаар төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулж, 52,043.4 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 73,297.9 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагыг тайлант онд бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19,562.8 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 30,715.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 41,399.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оноос эмнэлгийн үйлчилгээг цахимжуулан, E-Hospital программ хангамж ашиглах болсны улмаас их эмч, бага эмч нарт нэн шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж бэлтгэн төсвийн хөрөнгөөр худалдан авсан 16,221.4 мянган төгрөгийн , үнэ төлбөргүй хүлээн авсан 80,919.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 25,885.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өглөгийг тайлант онд бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр 511,854.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 37,841.8 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагаанаас 96,287.0 мянган төгрөгийн, нийт 645,982.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 зорилтын 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 645,982.8 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 37,841.8

мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 511,854.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 96,287.0 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 37,841.0 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 660,915.3 мянган төгрөгийн, нийт 698,756.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 634,055.6 мянган төгрөгийг зарцуулж, 52,043.4 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 644,136.6 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 885,.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 250.4 мянган төгрөг, норматив зардал 42.3 мянган төгрөг, томилолтын зардал 732.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 9,723.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ				
1.1	80111-Төрийн байгууллагын тогтмол зардал	16,259.20	36,767.30	(20,508.10)	226.13
1.2	80112-Нийтлэг үйлчилгээ		1,074.50		
1.3	80302-Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон	320,347.00	317,302.29	3,044.71	99.05
1.4	81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	191,507.00	265,937.24	(74,430.24)	138.87
1.5	83603-Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан	96,287.00	29,795.64	66,491.36	30.94
Дүн		624,400.20	650,876.97	(26,476.77)	104.24

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 250.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 710.0 мянган төгрөг, нийт 960.0 мянган төгрөг төвлөрч, тээвэр шатахууны зардалд 250.0 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 710.0 мянган төгрөгийн тус тус зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж, худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байх, нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтөлж байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор Н.Тэмүүжин гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/3 дугаар албан бичгээр 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 607,891.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,118.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 6,838.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 885,9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 250.4 мянган төгрөг, нормативд зардал 42.3 мянган төгрөг, томилолтын зардал 732.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 9,723.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 170 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 170 мэдээллээс 170 мэдээллийг хугацаандаа бүрэн мэдээлсэн байна.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих нийт 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтаас 1 харилцагч байгууллагын 7,909.4 мянган төгрөгийн худалдан авалтыг мэдээлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд байршуулах мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт, хуулийн хугацаанд багтаан мэдээлж, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 38,646.1 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 64,841.6 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс 6,747.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3,741.5 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилт 85 хувьтай.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	6,747.9	2	6,747.9	100.0
Төлбөрийн акт	-	-	-	-	-
Зөвлөмж	4	58,093.7	3	3,741.5	70.0
Нийт дүн	6	64,841.6	5	10,489.4	85.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 105,483.2 мянган төгрөгийн 8 зөрчил илэрснээс, 880.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 83,043.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлж, 21,559.8 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 880.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд батлагдсан төсөвт тусгагдаагүй, тэмцээн уралдааны шагнал урамшуулал, бооцоонд нийт 880.3 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн зориулалт бусаар зарцуулсан мөнгөн хөрөнгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар 83,043.1 мянган төгрөгийн зөрчил арилгах 3 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 33 нэр төрлийн 49,710.8 мянган төгрөгийн биет хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнө аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Ковид-19 цар тахлын үед ажилласан албан хаагчдад олгох улаан бүсэд ажилласны хөлс 33,332.3 мянган төгрөгийг өмнөх онд ажилчидтай холбоотой өглөгөөр тусгаагүй, тайлант оны эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс олгосон нь: Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тасалбар болголт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн нягтлан бодох бүртгэлийг бүрэн аккрузал сууриар хөтөлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Б/68 дугаар "Эд хөрөнгийн тооллого явуулах тухай" тушаалаар тооллогын комиссыг 4 хүний бүрэлдэхүүнтэй томилсон боловч тооллогыг биетээр гүйцэтгэж баталгаажуулаагүй,

үр дүнг хэлэлцээгүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/", мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн Хөрөнгө, бараа материалын жилийн эцсийн тооллогыг бодитой гүйцэтгэж, тооллогын үр дүнг хэлэлцэн баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 6 харилцагч байгууллагын 18,477.5 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх" заавартай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаж байх.

2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд ажил олгогчоос төлөх 542.5 мянган төгрөгийн НДШ-ийг цалингийн зардлаас гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

3. Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 42 нэр төрлийн 1,798.5 мянган төгрөгийн эм боох материал /эм, вакцин/ бүртгэлтэй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам,

заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.22-д "Төсөвт байгууллага нь бараа материалын өртгийг тодорхойлохдоо эхэлж авсныг эхэлж зарлагдах аргыг ашиглана. Эхэлж авсныг эхэлж зарлагдах аргын үед эхэлж худалдан авсан бараа материалыг эхэлж зарцуулна" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг зарцуулахдаа эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг ашиглаж хэвших.

4. Авлага, өглөгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант онд ажиллагсадтай холбоотой 741.2 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тасалбар болголт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой зарцуулж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацаанд батлагдсан төсөвт тусгагдаагүй, тэмцээн уралдааны шагнал урамшуулал бооцоонд нийт 880.3 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.	1	880.3	1	880.3					-	-	-	-
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 33 нэр төрлийн 49,710.8 мянган төгрөгийн биет хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй.	1	49,710.8			1	49,710.8			-	-	-	-
Ковид-19 цар тахлын үед ажилласан албан хаагчдад олгох улаан бүсэд ажилласны хөлс 33,332.3 мянган төгрөгийг өмнөх онд ажилчидтай холбоотой өглөгөөр тусгаагүй, тайлант оны эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс олгосон.	1	33,332.3			1	33,332.3			-	-	-	-
Байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Б/68 дугаар "Эд хөрөнгийн тооллого явуулах тухай" тушаалаар тооллогын комиссыг 4 хүний бүрэлдэхүүнтэй томилсон боловч тооллогыг биетээр гүйцэтгэж баталгаажуулаагүй, үр дүнг хэлэлцээгүй.	1	-			1	-						
Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 6 харилцагч байгууллагын 18,477.5 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй.	1	18,477.5					1	18,477.5				
Тайлант хугацаанд ажил олгогчоос төлөх 542.5 мянган төгрөгийн НДШ-ийг цалингийн зардлаас гүйлгэн зарцуулсан.	1	542.5					1	542.5				
Тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 42 нэр төрлийн 1,798.5 мянган төгрөгийн эм боох материал /эм, вакцин/ бүртгэлтэй.	1	1,798.5					1	1,798.5				
Тайлант онд ажиллагсадтай холбоотой 741.2 мянган төгрөгийн авлага үүсэн.	1	741.2					1	741.2				
Дүн	8	105,483.2	1	880.3	3	83,043.1	4	21,559.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<u>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</u>										
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих нийт 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтаас 1 харилцагч байгууллагын 7,909.4 мянган төгрөгийн худалдан авалтыг мэдээлээгүй	1	7,909.4	-	-	-	-	-	-	1	7,909.4
Дүн	1	7,909.4	-	-	-	-	-	-	1	7,909.4

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn